

*Бадамванчиг Ш.*

### БУРХАН ШАШНЫ ТЭМЦЛИЙН ҮЗЛИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

В статье рассмотрена история буддийского учения в свете «теории борьбы». Согласно которой, буддизм появился в результате борьбы, и развивался в борьбе. История буддийской религии на протяжении 2500 лет – это история борьбы. В то же время в условиях существования как внутренней, так и внешней борьбы, становится актуальной «учение об умирении борьбой». Автор полагает, что буддийская теория борьбы – это есть теория освобождения.

*Ключевые слова:* буддизм, борьба, философия буддизма, история буддизма

*Badamvanchig Sh.*

### ON THE VIEWS OF BUDDHISM ON STRUGGLE

Buddhism originated in the midst of struggle and has been developing in struggle. The two thousand five hundred years history of Buddhism has been a history of struggle. While there exists external and internal struggle, the doctrine of pacification by struggle becomes important for «the liberation».

*Key words:* Buddhism, history of Buddhism

«Бурхан шашин бол даруй хамаг нээлттэй гүн ухааны ёс учир мөн, дэлхий дээрх хамгийн багтаамжтай шашин суртахуун болно» [Lao Zheng Wu, 1999: 52] гэдэгчлэн, бурхан шашин бол бүх хүн төрөлхтний соёлын өв хөрөнгө мөн. Бурхан шашны онолыг «тэмцлийн зоригийг бууруулдаг мунхрууллын онол» гэж үздэг тэдгээр хүмүүс бурхан шашны үүсэн бүрэлдэж хөгжин мандсан түүхийг гүйцэд ойлгосонгүй мөртөөн бурхан шашны дотоод ухааны «номхотгохуй онол»-ын үнэн бодит агуулгыг буруу ойлгосноос болжээ. Бурхан шашин нь тэмцлийн дунд бий болж, тэмцлийн дунд хөгжин бузгайрсан хоёр мянга таван жилийн тэмцлийн түүхтэй юм. Шагжамунийн нэг нас бол гадаад дотоод хоёр их тэмцлээр дамжин, ертөнцийн хүмүүсийн гарах зам болох бурхны мөрийг заасан байна. Бурхан шашны дотоод ухааны «номхотгохуй онол» бол зарчимгүй «бууж өгөх» онол биш. Үнэндээ бурхан шашны онол нь «тэмцлийн үзэл»-ээр дүүрч, бий болсон тэр цагаасаа эхлэн тэмцлийг ер нь орхисонгүй. Хамаг амьтныг номхотгоход тэмцэл хэрэгтэй. Тэмцэл үгүй бол номхотгол

байхгүй юм. бурхан шашны «номхотгохуй онол» бол «тэмцэхүйн онол» мөн. Тэмцэлгүй номхотгол гэж байхгүй мөртөөн номхотголгүй тэмцэл бол ялагдал болж, тэмцлийн зориггүй бол «номхотгохуй онол»-ыг дурдсаны чухалгүй. Бид эрхбиш бурхан шашны хөгжилт түүх ба «номхотгохуй онол»-ын үнэнхүү утга санааг гүнзгий судлан шинжилбэл сая түүний тэмцлийг ил тод олж харах болно. Бурхан шашны тэмцлийн онолын зорилго, арга хэлбэр нь бусад тэмцлийн онолыг бодвол нууцхай мөртөөн мэргэн байж, ялагдашгүй болохыг зорьсон байна. Хэрвээ бурхан ном нь тэмцлийн үзэлтгүй бол «ялагдашгүй бурхан шашин» гэж нэрийдэгдэхгүй. Ялж ялагдах бол тэмцлээр дамжин бий болдог. Тэмцэлгүйгээр ялах гэдэг бол байж болшгүй. Бурхан шашин нь «номхотгохуйн онол» гэж дурдсанаас бус «бууж өгөх онол» гэж дурдсангүй. Гагц ертөнцийн хүмүүс үгийн утгыг шинжлэлгүй мунхагаар шүтсэн буюу нэгэн засаг төрөөс бурхан шашныг ашиглаж, өөрийн засаг төрөө тогтоон байлгах үүднээс «номхотгохуйн онол» болгож, бурхан номыг гажуудуулсан байна.

Нэг. Бурхан шашны мөрт орох анхны тэмцэл

Ертөнцийн хар хүн байснаасаа шашны мөрт орох үед үзэл санаан дээр хамаг анхны тэмцэл эхэлдэг юм. Хүний ертөнцийн сайн сайхан гэр бүл, өнөр баялаг эд агуурс бүхнийг ардаа орхиж дийлэх эсэх, шашны мөрийг хөөж мөнхийн шидийг олж дийлэх эсэх, ямар шашны мөрөөр замнавал зөв оновчтой эсэх бол хурц ширүүн үзэл санааны тэмцлээр дамжин шийдвэрлэгддэг. Шагжамуни гэрээс гармагц «бурхан шашин»-ы үүдэнд орсон бус. Тэр үед бурхны шашин гэж байхгүй. Харин бирман шашин зэрэг шашин байж, Шагжамуни ч тухайн үед нийтэм дэлгэрч байсан ашиг тусаар зорилго болгосон «Самадийн бясалгал», «хатуужин явах» замаар явж, эцэстээ үнэн мөр бус болохыг мэдэж, бодь модны доор мөрийг бясалган, бусад шашнаас онцлогдсон бурхны ёсыг үүдэн байгуулсан байна. Тухайн үед Шагжамунийн хамгийн итгэлт таван нөхөр нь ч түүнээс салан явсан билээ. Шагжамуни үнэн мөрийг олсны сүүлд хамгийн түрүүнд түүнээс салж явсан таван нөхөр нь ч шавь болж даган ирж, дараа нь Шарийн хөвүүн, Модгалживу ахмад хөвүүн нар хойно хойноосоо дагалцан ирсэн нь бүр тэмцлээр дамжсан гэдэг нь илэрхий байна.

Хоёр. Бурхан шашны дотоодын тэмцэл

Бурхан шашны дотоодын тэмцэл ч түүхээс аваад оршоор ирсэн юм. шагжамуни бурхныг нирваан дүр үзүүлсний хэдэн сарын дараа Энэтхэгийн Ражагриха балгадын гаднах долоон навчит агуйд бурхан багшийн номыг эмхэтгэх «таван зуун аяга тахимлаг»-ийн их цуглаан болж, «аахар шаахар санваар»-ын асуудал дээр хэлэлцээн болж дотоод тэмцэл эхэлсэн байна. Дахин зуун оны дараа хоёр дахь удаагийн эмэтгэх «долоон зуун аяга тахимлагийн оролцсон эмхэтгэл»-ийн цуглаан болж, мөн сахил санваарын учраас шалтгаалагдаж, дорно зүгийн системийн «олонхтоны аймаг» ба өрнө зүгийн «уламжлалын бат агчийн аймаг» гэж хоёр салбарлан гарч, дөрвөн зуун жилийн хооронд хорин аймаг бүлэг болж задарсан байна. Төвдийн бурхан шашин нь Сажагийн бүлэг, Гаржүдбагийн бүлэг, Нимавагийн бүлэг, Гэлүгвагийн бүлэг, Шалын, Гадамбагийн бүлэг гэж зургаан бүлэг болж тэмцэл ер тасарсангүй. Юань улсын үед төвдийн бурхан шашин монгол оронд уламжлагдах үед Сажавагийн бүлэг ба Гаржүдбагийн бүлгийн тэмцээн өрнөж, Гармавагийн хоёр гар шавь алагдаж, Гармаа багш хэдэн жил Хятадад хоригдсон нь үнэндээ шашны хоорондох тэмцэл мөн. Улсын багш Пагваас зөвшөөрөлгүй бол Гармавагийн хоёр шавь алагдах явдал гарахгүй юм. Бурхан гурван эрдэнийн доторх бурхан эрдэнэ нь адил, ном эрдэнэ ч адил, гагцхүү хувраг эрдэнэ нь хоорондоо тэмцэлдэн, аймаг бүлэг болж задран салж тэмцэлдсээр иржээ. Бурхан шашныг судалдаг хойчийн эрдэмтэн бурхан шашны аймаг бүлэг болж задарсанг «аахар шаахар санваар»-аас болсон гэж дүгнэн ярьдаг. Үнэндээ санваараар шалтгаан болгосон хувь хүн буюу аймаг угсаатны хоорондох ашиг тусын тэмцэлдээн болох нь илэрхий билээ.

Гурав: Бурхан шашин ба гадаад шашны хоорондох тэмцэл

Бурхан шашин бий болсон тэр цагаас аваад гадаад шашинтай үхэж сэхэхийн тэмцэл явуулсан юм. бурхан шашин бий болох үед Энэтхэгт бирманы шашин, жайн шашин зэрэг маш олон шашны бүлэг байсан билээ. Бурхан шашин нь эдгээр шашинтай хэдийвээр илт жадын тэмцэл явуулсангүй ч үзэл санааны талаар маш хурц ширүүн тэмцэлдээнийг өрнүүлсэн гэдэг нь тодорхой юм. Шагжамуни бурхан бодь модны доор бясалгал хийхдээ шимнусын хаантай эвлэршгүй хатуу тэмцлийг явуулж ялсан юм. Энэ тэмцэлд

шимнусын хааны аливаа дайралт нь Шагжамуни бурхны бат итгэлийг өчүүхэн ч гуйвуулж чадсангүй. Энэ бол Шагжамуни бурхны биедээ бат итгэсэн тэмцлийн зориг ба ялагдашгүй тэмцлийн хүчтэй байхыг харуулж чаджээ. Бурхан шашин Энэтхэг орноос Дундад улсад уламжлагдахдаа гадаадын тэмцэл ер нь зогссонгүй. Хятадын Бумбын шашин, Төвдын бонгийн шашин, Монголын бөөгийн шашинтай хурц ширүүн тэмцлийг өрнүүлэн, өөрийн гэх орон зайгаа эзэлсэн боловч, эдгээр тэмцэл нь одоо ч гэсэн сүүл тасраагүй байсаар билээ.

Дөрөв: Бурхан шашин ба засаг төрийн тэмцээн

Бурхан шашин ба төр засгийн тэмцэл мөргөлдөөн ч түүхэн дээр нэлээд хэд удаа үүссэн байна. Төр ба шашны мөргөлдөөнд бурхан шашинтай цаг ялагдах боловч, эцэстээ төр мөхөж, бурхан шашин дахин сэргэн манддаг. Түүхэн материалыг ажиглахад мөхсөн төр дахин мандсан ер байхгүй. Харин буурсан шашин дахин мандан сэргэж, хоёр мянган жилийн турш маш олон төрийг өнгөрөөж ирсэн байна. Үнэндээ бурхан шашин төрийн явдалд оролцох бол зүй ёсны учир биш. Шагжамуни төрөө хаяж шашинд орсноос бус, төр шашин хоёрыг хамтруулан атгасан ч бус. Мөн ч өргөтгөх бол зохисгүй гэдгийг бурхан шашны сахил санваарт ч цаазалж байдаг. Үүний зэрэгцээгээр төр засаг ч шашин суртахууныг ашиглаж, өөрийн ноёрхолоо бэхжүүлдэг нь хамаг амьтныг бодсон бус юм. иймээс ашиглаж болох үед бурхан шашныг тэд авч, ашиг хорын мөргөлдөөн гарах үед дарангуйлах засаг явуулдаг байжээ. Дундад улсын түүхэн дээр «гурван эүн зовлон» гэж гурван төрд бурхан шашныг ихээр дарангуйлсан байна. Төвд оронд «Ландарма дарангуйлал» зэрэг шашин төрийн их тэмцэл гарч өнгөрсөн юм. Бурхан шашинд төр гүрнийг хавсарч улсыг засах үүрэг хариуцлага ч байхгүй юм. Харин хамаг амьтныг үхэж төрийн орчлоос салгах бол түүн хамаг эцсийн зорилго мөн. Бурхан шашин нь нэг зохион байгуулалтын хэлбэрээр илэрсэн тэр цагаас эхлэн гадаад шашин ба шашны дотоодын тэмцэл, засаг төр лугаан тэмцэл дунд үргэлжлэн, тэмцэлгүй орчин тойрон, тэмцэлгүй цаг хугацаа гэж ерөөс алга билээ.

Тав: Номхотгохуйн онол бол зүй ёсонд тохиролцох явдал мөн.

Бурхан шашны сургаалыг номхотгохуйн сургаал ба тогтоох сургаал (явдлын сургаал) гэж хоёр их системд хувааж болдог.

Номхотгохуйн онолд өөрийгөө номхотгох ба бусдыг номхотгох гэж байдаг. Номхотгох гэдэг бол зарчимгүй номхон шударга боол зардсан болох гэсэн явдал биш. Мөн ч ямар нэгэн эрх сүртнээс бусдыг захирах гэсэн санаа ч бус. Харин хоёр үнэний зүй ёсонд номхон шударга байж, зүй ёсноос тэрслэх бодол сэтгэл үйл ажиллагааг хориглож хэлсэн санаа юм. Хүн үнэндээ заншилын боол, даруй зүй ёсны боол мөн. Харин ямар нэгэн эрх сүртэн буюу төр гүрэн боол биш. Бурхан шашны номхотголын онолд маш олон агуулга агуулагдаж байдаг. Дан ганц шударга болох явдал биш. Мөн ч ямарваа нэг хүн буюу төрд номхон шударга болох гэсэн явдал ч бус. Гэрээс гарч шашны ёсонд орсон шашны ёсоор биеэ номхотгож, гэрээс үл гарсан ертөнцийн ёсоор бие засах хэрэгтэй. Төрийн ёс бол ертөнцийн ёсонд багтагдаж, мөн ч цаг үеийн хувиралт, төрийн мөргөлийг дагалдан устдаг. Зарим үед төрөөс ёс бусын дүрэм тогтоол тогтоох үзэгдэл ч гардаг. Энэ бүхэн нь бүр зүй ёс ба зүй бусын тэмцлээр дамжин эцэстээ устдаг. Ёсыг олсон ялагдашгүй байдаг бол хорвоо ертөнцийн жам ёс юм. Бурхан шашны номхотгохуйн онолбол хүн төрөлхтөний хоёр үнэний зүй ёсонд тохиролцохыг шаардсан явдал мөн.

Зургаа: Номхотгохуйн онол бол өөрийгөө хүчирхэгжүүлэх явдал мөн.

Ертөнцийн хамгийн хүчирхэг юм бол эрх зэрэг эд мөнгө бус, буу зэвсэг ч бус, харин зүй ёс бол хамгийн хүчирхэг байдаг. Бурхан шашны номхотгол нь юмны өмнө өөрийгөө номхотгохоос эхэлдэг. Учир нь өөрийгөө номхотгох чадалгүй бол бусдыг хэрхэн номхотгох буй. Зүй бус нь зүй ёсыг хүлээсэлдэг ч зүй ёс бол зүй бусыг ялдаг. Өөрийгөө номхотгоход маш их тэмцэл агуулагдаж байгааг хүмүүс ер нь сэрж мэддэггүй. Хүмүүс «өөрийн биетэйгээ тэмцэлдэх» бол бурхан шашны хамгийн их тэмцлийн онол гэж хэлж болно. Тэмцэл гэгч эсрэг тэсрэг хоёр талын хооронд л оршдог, яахан ганц өөрийн талд тэмцэл орших буй гэж тэмцэлд боддоггүй нь олон юм. Бусадтай тэмцэлдэхэд тун амархан байж, ямар ч өршөөл гэж үгүй, хутгыг чадлын хэрээр хэрэглэдэг. Гэтэл өөрийн биед хутга хэрэглэх гэгч энгийн хүний хийж чадах явдал бус. Өөрийгөө ёсонд нийцүүлж, биеэ номхотгох чадагч бол үнэнхүү баатар идэд авьяас билигтэн мөн. Нагаржунагийн «Чарьяа аватар»-д «урин хурьцал зэрэг нь гаргүй, баатар сэцэн ч бус

байгаад намайг боол болгоод, миний сэтгэлд оршсоор, зоригоороо надыг хорлоход би хилингүй хүлцэх бөгөөд оронгүйгээс хүлцэх хэрэгтэй болжээ» [Сацлашгүй Зонхава бээр... Х. 323] гэж номлосон нь хүмүүс нисванисын хүлээсэнд, хүлээслэгдэж байгаагаа өчүүхэн ч сэрж мэддэггүй байжээ. Хүмүүсийн бие хэл сэтгэлтэйгээ тэмэл хийх гэгч маш хурц ширүүн мөртөөн нарийн будлиантай байж, агуу их зориг цөс авьяас билиг хэрэгсэх юм. Бурхан шашны номхотгохуйн онолын үнэн утгыг мэдэх бол туйлын чухал байж, харин тэмцлийг огоорох гэсэн санаа огт биш юм. Зүй ёс бол ялагдашгүй байдгаас зүйд нийцсэн ялагдашгүй хүчирхэг их болдог.

Долоо: Номхотгохуйн онол бол хэв дуурайлын явдал мөн.

Хэв дуурайлын хүч бол хамгийн их итгүүлэх хүчтэй ялагдашгүй заан сургалтын арга хэлбэр мөн. Бурхан шашны бусдыг номхотгох онолоор авч хэлбэл, номхотгохын арга хэлбэр нь төрийн хууль цаазыг бодвол маш боловсон байж, баларлаг бүдүүлэг цаг үеэс давсан дээд хэмжээний боловсон нийгэмд зохицолдсон, илд жадаар цогцыг тамтаглан, зарлиг заавраар оюун санааны даралт үзүүлэн номхотгох бус, харин номхотгогдахууны ухамсарт түшиглэж, өөрийн биеэр хэв дуурайл үзүүлэн, бусдыг дотоод сэтгэлээс нь бишрүүлэн дагуулдаг тул «үзүүлэгч бурхан» гэж нэрлэдэгийн учир түүнд буй. Мөн ч хар албаар цаг бусыг хайхралгүйгээр дарангуйлан номхотгох бус, харин сэхээрүүлэн номхотгохоор зорилгоо болгодог. Энэхүү номхотгол нь маш удаан даамгай хүлцэнгүй тэцлийн аргыг авдаг байна. Учир нь бол бурхан шашны хамаг эцсийн зорилго бол хамаг амьныг мунхагаас авран, сэхээрлийн замаар бодийн мөрд оруулан, бурхан болгох явдал болно. Энэхүү ажиллагаа нь хүний нэг хэдэн төрөлд биелүүлж дийлэх ажил биш. Хүний нэг насыг хорвоо ертөнцийн цаг хугацаатай харьцуулвал гялбаан гялбах мэт охор байдаг тул охорхон хугацаанд номхотгохыг биелүүлэх гэж албадах бус. Харин үйл үрээ боловсрол, ерөөл барилдлагын завшааныг хүлээдэг. Энэхүү тэмцлийн арга нь хүмүүст «бурхан шашинд тэмцлийн зориг байхгүй» гэсэн эндүү ойлголтыг өгдөг байна.

Найм: Номхотгохуйн онол бол номхон шударга бууж өгөх явдал бус.

Бурхан шашны «номхотгохуйн онол» дахь номхотгол бол дан ганц номхон шударга болох явдал биш. Харин зүй ёсны өмнө

номхорч, зүй бусын өмнө хүчирхэгжих онол мөн. Учир нь зүй ёс нь зүй бусыг ялдаг, хэдийгээр зүй ёс зарим үед нугарал бүдрэлд учирдаг ч, хамгийн эцэст ялалт олдог тул бурхан шашныг «ялгуусны шашин» гэж хэлдэгийн учир үүнд буй. Иймээс ялалтад хүргэдэг зүй ёсоор замнагчид нь зүй бусын өмнө хамгийн их хүчирхэг этгээд болж зогсдог. Харин зүй ёс ба зүй бусыг ялгалгүй, аливаан өмнө номхрон толгой бөхийх гэсэн явдал бус. Мөн ч бусдыг номхотгон дарлах гэсэн явдал нэн ч бус. Бурхан шашны номхотгохуйн онолын өөрийгөө номхотгох бол өөрийгөө хүчирхэгжүүлэх арга байж, бусдыг номхотгох бол зүй ёсонд оруулан хүчирхэгжүүлэх арга мөн. Бурхан шашны хүн төрөлхтөнийг түүний сэхээрэлтэд түшиглэн номхотгох бол ямарваа засаг төрд байхгүй дээд хэмжээний боловсон тэмцлийн арга ухаан мөн. Өөрийгөө хүчирхэгжүүлэх бол ялалт олохын бат суурь болно. Бурхан шашны хэдэн мянган жилийн турш ялагдалгүй тэмцэж ирсэний шалтгаан үүнд байдаг. Ямар нэгэн засар төр буюу шашны дээд давхаргатнаас өөрийн нүдний өмнөх эрх ашиг, эд мөнгөө батлахын төлөө бурхан шашны номхотгохуйн онолыг гаждуулан ашиглажээ.

Ерөнхийлөн хэлбэл, бурхан шашны онол нь тэр чигээрээ тэмцлийн онолоор дүүрч байна. Зөрчил тэмцлээс салсан хэрэг бодис гэж оршдоггүй. Зөрчил бол хэрэг бодисын орших хэлбэр мөн. Бурхан бол их, учир нь тэр бол нэгэнтээ сэхээрсэн, өөрийн биеэрээ дууриал болжээ. Бурхан ном бол агуу их, учир нь тэр бол сэхээрлийн замыг заасан үнэн ёс, гэтэл хувраг бүхэн агуу их, учир нь тэр бүрмөсөн сэхээрээгүй шавь, сэхээрлийг зорин, мунхагтай тэмцэлдэж, мунхагийн дундаас сэхээрч, сэхээрлийн дундаа мунхагтан буяны садан. Эдгээр садны зарим нь хоёр мянган жилийн турш бурхан номыг ойлгох ба ойлгохгүйн дундуур, аймаг бүлэг байгуулан нэр төр хөөцөлдөн, төр засагтай холбоолон, би чамаг дэмжиж, би намайг өргөх арилжааны ном болгож, ашиг тустайгаа холбож, хэсэг бусгаар гажуудуулан, бурхан номын үнэнхүү утга санааг өөрчлөн, хувь заяаны онол, мунхарлын онол болгон үхмэл шүтүүлж, хамаг амьтны ашиг тусыг ардаа таягдсанаас, бурхан ном нь ертөнцийн хүний сэтгэлд итгэл хүндээ алдаж байгаа учраас бид эрхбиш бурхан номын утга санааг нэвтэрхий гүнзгий ойлгон судлах хэрэгтэй.

### Ашигласан ном

1. Сүмбэ хамба Ишбалжир. Ишбалжирын бурхан шашны түүх. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 1993-10.
2. Баатар. Монголын ёс зүйн үзэл санааны түүх. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 2002-5.
3. Сацлашгүй Зонхава бээр зохиосон их бодь мөрийн зэрэг оршвой. Модон бар.
4. Үнэн. Монголын шашин суртахууны үзэл санааны түүх. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 2003-1.
5. 劳政武. 佛教武律学 宗教文化出版社 1999-9
6. 释印顺. 印度佛教思想史 中华书局 2011-3.
7. 王森. 西藏佛教发展史略 中国藏学出版社 2010-1.
8. 印度佛教汉文资料选编 北京大学出版社 2010-11.

### References

1. Sumbe khambo Ishbaljir. Ishbaljiryn burkhan shashny tuukh. Uvurmongolyn ardyn khevleliin khoroo, 1993-10.
2. Baatar. Mongolyn yos zuin uzel sanaany tuukh. Uvurmongolyn ardyn khevleliin khoroo, 2002-5.
3. Satslashgui Zonkhava beer zokhioson ikh bodi muriin zereg orshvoi. Modon bar.
4. Unen. Mongolyn shashin surtakuuny uzel sanaany tuukh. Uvurmongolyn ardyn khevleliin khoroo, 2003-1.
5. Lao Zheng Wu. Fo jiao wu lu xue. Zongjiao wenhua chubanshe, 1999.
6. Shi Yinshun. Yindu fojiao sixiangshi. Zhonghua shuju. 2011-3.
7. Wang Sen. Xizang fojiao fazhan shilue. Zhongguo zang xue. 2010-1.
8. Yindu fojiao han wen zi liao xuan bian. Bei jing da xue chubanshe, 2010-11.